

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030
/I үе шат 2016-2020 он/

2016 оны эцэс

№	Зорилт	Хариуцах нэгж	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ
2.1.3. Аж үйлдвэрийн салбар				
Зорилт 3. Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана.				
1	Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээний 20 хувийг Евро 4 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах, зэс хайлуулах, алт цэвэршүүлэх, улмаар газрын тос, байгалийн хий, занар, нүүрс боловсруулах, химийн бүтээгдэхүүн болон бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх.	ХҮБГ	<p>Алт цэвэршүүлэх үйлдвэр барьж байгуулах боломжийн талаар санал боловсруулж Монголбанкны Ерөнхийлөгч, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулан хамтарсан Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. -40</p> <p>БНЭУ-аас олгох хөнгөлөлтэй зээлийн хөрөнгөөр “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”-ийг санхүүжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг Сангийн яамтай хамтран боловсруулж ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын 2016 оны 12 дугаарын 14-ний өдрийн хуралдаанаас "Монгол Услын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын 1 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн тухай" тэмдэглэл гарсан. Хуралдааны тэмдэглэлийн дагуу БНЭУ-аас олгох зээлийн хөрөнгөөр төслийг санхүүжүүлэх асуудлаар хоёр улсын хооронд байгуулагдах зээлийн хэлэлцээрийг УИХ-ын төсвийн, эдийн засгийн, аюулгүй байдлын байнгын хороодоор тус тус хэлэлцүүлсэн. УИХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангасан. Боловсруулах үйлдвэрийн байршлыг урьдчилсан байдлаар Дорноговь аймгийн Сайншанд суманд байгуулахаар төлөвлөж, холбогдох дэд бүтцийн судалгааг гаргаад байна. Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай 59 дүгээр тогтоолыг батлуулсан. Уг тогтоолоор Монгол улсын Засгийн газар, БНЭУ-ын Экспорт-Импорт банк хоорондын 1 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийг хэрэгжүүлэхээр тогтсон. Үүнтэй холбогдуулан УУХҮСайдын 2017 оны А/26 тоот тушаалаар “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийг байгуулж, ажлын даалгавар боловсруулан батлуулсан. Яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/16 тоот тушаалаар “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх компанийг сонгон шалгаруулах үүрэг бүхий</p>	40

			<p>үнэлгээний хороог байгуулж, төслийн зөвлөх компанийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, хураангуй жагсаалтад орох зөвлөх компаниудыг сонгож тендерт оролцох урилгыг хүргүүлээд байна. -40</p> <p>Төслийн нэгж байгуулах тухай Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 107 дугаар тогтоолоор зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэхээр тогтсон. Үүнтэй холбогдуулан Ажлын хэсэг байгуулах тухай Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 114 дүгээр захирамжаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр" барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгийн 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг Өмнөговь аймгийн Ханбогд суманд барих асуудлыг дэмжиж дүгнэлт гаргасан. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулж бүх яамдаас санал авч тусгасан. Тогтоолын төслийг 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж тогтоол гарсан. Төслийн нэгжийн 2017 оны ажлын төлөвлөгөөний дагуу төслийн хөрөнгө оруулагчийг 09 дүгээр сард сонгон шалгаруулахаар ажиллаж байна. -40</p>	
Зорилт 4. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана.				
2	Жилд 100.0 мянган тонн ган бөмбөлөг, тээрмийн хуяг, бусад эд анги үйлдвэрлэх хүчин чадал бүхий тоног төхөөрөмжийн үйлдвэрийг ашиглалтад оруулах.	ХҮБГ	УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/63 тоот тушаалаар "Зөвлөх компаниудын ажлын тайлан гүйцэтгэлд хяналт тавих ажлын хэсэг"-ийг байгуулж "Дархан-Сэлэнгийн бүсэд байгуулах хар төмөрлөгийн цогцолбор төсөл"-ийн урьдчилсан ТЭЗҮ болон БОННУ-ний дунд шатны тайланг 2016.12.14-ны өдөр хүлээн авсан. Тус ажлын хэсгээс урьдчилсан ТЭЗҮ-ийн тайланг хэлэлцэн, Үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах зорилгоор Төмөртэйн орд дээр байгуулах нойтон баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг 3 сая тонн хүдэр боловсруулж, 2 сая тонн нойтон баяжмал боловсруулах хүчин чадалтай байхаар тооцох, цаашид банкны ТЭЗҮ-д оруулах санал боловсруулж, Зөвлөх компани /Канад Улсын "ХАЭЧ" компани/-д хүргүүлсэн. ТЭЗҮ болон БОННУ-ний эцсийн тайланг 2017 оны 07 дугаар сард бүрэн хүлээж авахаар ажиллаж байна. Хар төмөрлөгийн цогцолбор байгуулах төслийн хүрээнд 500 мянган тонн.жил шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах ажил 2018 онд, гангийн үйлдвэрт өргөтгөл хийж, хүчин чадлыг нэмэгдүүлэн жилд 350 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажлыг 2019 онд, 2020 онд жилд 500 мянган тонн ангижруулсан төмрийн үйлдвэр, 350 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг ашиглалтанд оруулснаар дотоодын ган	40

			бүтээгдэхүүний хэрэгцээг хангаж, импортын хэмжээг бууруулах боломж бүрдэнэ гэж үзэж байна. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК евро стандартад нийцсэн ган бөмбөлгийн үйлдвэрийг 2017 оны 01 сарын 28-нд ашиглалтанд оруулсан ба 2017 онд багтааж цувимал аргын ган бөмбөлгийн үйлдвэр ашиглалтад оруулснаар давтах болон цувих аргын хоёр үйлдвэрийн жилийн нийт хүчин чадал 60 мянган тоннд хүрч, дотоодын хэрэгцээний 80 гаруй хувийг хангах юм. -40	
2.1.4.Эрдэс баялгийн салбар				
Зорилт 1.Геологийн салбарын хөгжлийг дэмжинэ.				
3	Геологи, геохими, геофизикийн бүх төрлийн судалгааны ажлыг иж бүрнээр гүйцэтгэх чадавхийг бэхжүүлж, судалгааны ажлын арга, аргачлал, зааврыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн заавар, аргачлалтай уялдуулан шинэчлэн боловсруулах, Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн 1:200000 масштабын зураглалд бүрэн хамруулан, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 40 хувьд гүйцэтгэх.	ГБГ	<ul style="list-style-type: none"> - Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох ажлаар нутаг дэвсгэрийн 86%-ийг бүрэн хамруулсан бөгөөд 2016 онд Улсын геологийн зураглал /УГЗ-200/ төслийн хүрээнд Дорнод Монгол-VI, Дорнод Монгол-VII, Төв Монгол-V, Төв Монгол-VI төслүүдийн суурин боловсруулалтын ажлыг хэрэгжүүлж дууссан. Үр дүнгийн тайланг 2017 онд хүлээн авснаар 100% хамрагдаж дуусна. Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг К хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн.-100 - 2016 онд Тогоо хайрхан-50, Улаанбадрах-50, Баяндалай-50, Онц уул-50, Эмээлцэгийн нуруу-50 төслүүдийн үр дүнг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл /ЭБМЗ/-өөр хэлэлцэн хүлээн авснаар нийт нутаг дэвсгэрийн 34.6%-д 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгээд байна. Шинээр хэрэгжүүлэх 10 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлснээр нутаг дэвсгэрийн 5%-д ажил үргэлжлэн хэрэгжиж байна. 2017 онд нэмж нутаг дэвсгэрийн 1.5%-д төсөл хэрэгжүүлэхээр үнэлгээний хороог байгуулан ажиллаж байна.-90 	90
Зорилт 2.Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.				
4	Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлж, говийн бүсийн томоохон хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулах.	УУБГ БХЗГ	<ul style="list-style-type: none"> - Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/99 дугаар тушаалаар уул уурхайн тухай хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулах Ажлын хэсгийг байгуулж хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж 2016 оны 12 сарын 26-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүйн сайдаар батлуулсан. -30 - Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсантай холбоотойгоор үүсмэл ордыг ашиглах эрх зүйн орчин бүрдсэн. Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам"-ыг Засгийн газрын 2017 оны 02 сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан, үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журмын төсөлд олон нийтийн санал авах ажил хийгдэж байна. -30 - Уул уурхайн нөхөн сэргээлтийн асуудлыг Уул уурхайн тухай хуулиар зохицуулахаар хуулийн төсөлд тусгасан ба Олон улсын жишигт нийцсэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уурхайн хаалтын төлөвлөгөө боловсруулах, хаалтын санхүүгийн 	30

			<p>баталгаа гаргах зохицуулалтыг хуульчилж өгснөөр байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.-30</p> <p>“Алт олборлож угаах, хүлээлцэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, улсад тушаах үлгэрчилсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх ажлыг УУХҮЯ-ны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж үлгэрчилсэн дүрэм боловсруулах судалгааны ажил хийгдэж байна.-30</p>	
Хэрэгжилтийн дундаж				50,0

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2017 он